



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 17 өдөр

Дугаар A/37

Улаанбаатар хот

“Ай Ти Эм” Олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 105 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1200 дугаар захирамж, 2022 оны 155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 4.1.10, 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, иргэд, жуулчдыг хэрэгцээт мэдээ мэдээллээр хангах зорилгоор 2024 оны 10 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд Мишээл экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулагдах “Ай Ти Эм” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцсугай.

2. “Ай Ти Эм” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцуулахад төсвийн хавсралтаар баталж, шаардагдах 20,600,000 (Хорин сая зургаан зуун мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Үзэсгэлэнд оролцох бэлтгэл ажлыг хангаж, ажлын үр дүнг танилцуулж, тайлагнан ажиллахыг Мэдээлэл сурталчилгааны хэлтэс (Б.Энхцэцэг)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газар
2024 оны 10 дугаар сарын 17
өдрийн 11.37 дугаар тушаал
хавсралт

“АЙ ТИ ЭМ” ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦОХ ТӨСӨВ

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Үйл ажиллагааны тайз, хөгжим техник түрээсийн зардал /МАЖХ/	Багц	10,000,000	10,000,000
2	Үзэсгэлэнд оролцох талбайн тохижилт /PVC Хавтан хэвлэл/	72м ²	147,222	10,600,000
Нийт дүн				20,600,000